

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ГЕОПОЛИТИК, ГЕО-ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨРЧЛӨЛТ, ДАСАН ЗОХИЦОХУЙ

Доктор, профессор Д.Уламбаяр¹

Эдүгээ нэгд, Харилцан шалтгаалцал, даяаршлын үйл явц нийгмийн бүхий л хүрээг хамарч, гадаад, дотоод орчин маш хурдан өөрчлөгдөж, тиймээс ойрх ирээдүйн төлөв байдлыг ч урьдчилан төсөөлөх боломж тун бүрхэг байгаа нь өнөөгийн олон улсын харилцааны үндсэн шинж болов.

Хоёрт, Эдүгээ олон улсын хамтын ажиллагааны хамгийн чухал зүйл нь олон улсын эрхзүйн хэм хэмжээнд дэлхийн улс орнуудын тогтвортой байдлыг хангах, олон улсын харилцаа, геополитикийн орчинд урьдчилан таамаглаж болохуйц нөхцөл байдлыг хадгалах явдал тулгамдсан асуудал болсоор байна.

Гуравт, Хүчний тэнцвэрийг барихаас гадна ашиг сонирхлын тэнцвэрийг барих гэдэг маш чухал болов. Тийнхүү бие биенийхээ эрх ашигт хэрхэн нөлөөлөхгүй байх тухай асуудал чухал болов.

Дөрөвт, Төв рүү тэмүүлэх, төвөөс зугтаах хүчний аль аль нь үйлчилж буй даяаршлын эрин үед олон улсын харилцааны шинэ дэг журам төлөвших үйл явцын төгсгөлийг төсөөлөх боломж тун бүрхэг байгаа зэрэг санал, дүгнэлтүүд юм. Brexit, ЕХ-ны сорилт, АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн, ШХАБ, Евразийн Эдийн Засгийн Холбоо, Торгоны их замын мега төслийн үйл явц үүний тод илрэл юм.

Улс орнуудын өмнө дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, даяаршиж буй дижитал ертөнцөд дасан зохицоёос гадна, олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явцад нэгэн адил хэрхэн дасан зохицох тухай асуудал шинээр дэвшигдэн тавигдаж байна. Мөн гадаад бодлогоо тодорхойлохдоо: *economics of power* буюу хүчний эдийн засаг, *power of economics* буюу эдийн засгийн хүч гэсэн 2 зарчмийг баримталж байна.

Бид олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг журамд дасан зохицож, урагш алхах шаардлагатай.

ОХУ, БНХАУ-аар тэргүүлсэн олон улсын харилцааны олон туйлт төв төлөвших хандлага идэвхиж байгаа нь хүйтэн дайн дууссанаас хойш тогтсоор ирсэн олон улсын дэг журам, аюулгүй байдлын системд ноцтой нөлөө үзүүлж эхлэв хэмээн судлаачид үзсээр байгаа юм. Улс хоорондын харилцаанд шашин болон үндэстэн хоорондын мөргөлдөөн, иргэний дайн, газар нутгийн маргаан, дүрвэгсэдийн давалгаа, цөмийн болон баллистик пуужингийн хөтөлбөрөөр далайлгах, их гүрнүүдийн хоорондох ашиг сонирхлын зөрчил хурцдах төлөвтэй болж, эдийн засгийн хориг арга хэмжээ өргөжиж, тиймээс хүйтэн дайн дууссаны дараах үе төгсгөл болж, шинэ хүйтэн дайны үе эхэллээ хэмээн тэмдэглэх нь ч буй. Хэдийгээр их гүрнүүдийн цэргийн зардал нэмэгдэж байгаа ч энэ нь дайн гарах гол үндэслэл биш, харин аюулгүй байдлаа баталгаажуулж буй хэрэг, их гүрний байр суурь, сүр хүчээ харуулж буй хэрэг, хүчний дахин тэнцвэржүүлэлт, мөн орлогын чухал эх сурвалж байна.

Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байх гэдэг нь даяаршлын үед харьцангуй ойлголт бөгөөд тэгэх тусмаа дангаараа бүрэн хангах боломжгүй юм. *Үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь*

¹ Д.Уламбаяр. ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал

тасралтгүй үргэлжлэх үйл явц мөн бөгөөд үүн лүгээ үндэсний аюулгүй байдлын судалгаа, дүн шинжилгээ ч тасралтгүй хийгдэж байх учиртай ажгуу.

Бүс нутгийн болон олон улсын аюулгүй байдал, дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үр нөлөө, зах зээлийн конъюнктурын хувьсал, дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшиг, шинэ өвчний цар тахал, *hybrid* буюу уламжлалт бус аюул зэрэг геополитикийн гадаад орчин, төсөв, мөнгө, хөрөнгө оруулалтын бодлого, хүний эрхийн баталгаажилт, ардчилал, засаглалын чанар зэрэг геополитикийн дотоод орчны мэдэгдэхүйц хувьсал улс орны удирдлагыг богино хугацаанд оновчтой, шинжлэх ухааны үндэслэлтэй зөв шийдвэр гаргах, урьдчилан сэргийлэх дипломат ажиллагаа, хямралын менежментийг шуурхай хэрэгжүүлэхийг шаардаж байна.

Бид *нэгд*, Өрнөдийн хориг арга хэмжээтэй холбоотойгоор ОХУ-ын Алс Дорнодын бодлого, ялангуяа БНХАУ-ыг чиглэсэн бодлого идэвхижсэн нь Монгол Улсын геополитикийн ач холбогдлыг мэдэгдэхүйц өсгөв. Бид үүнийг дорвитой ашиглаж чадаагүй байна. *Хоёрт*, Орос-Хятадын харилцаа иж бүрэн стратегийн түншлэлийн баттай түвшинд хүрсэн нь Монгол Улсын гадаад хамгийн ойр орчин сайн байна гэсэн үг.²

БНХАУ Хятад, Оросын харилцаа хэзээ ч холбоотны харилцаанд эргэж очихгүй гэдгийг тэмдэглэсэн.

БНХАУ глобал эдийн засагт онцгой байр эзлэх болов. Хятадын үндэсний мөнгөн тэмдэгт ОУВС-гийн зээлжих тусгай эрхийн сагсанд баттай байраа эзэлж, олон улсын худалдаа, зээл тусламж, газрын тос, байгалийн хийн төлбөр тооцоо хятадын мөнгөн дэвсгэртээр хийгдэж, зарим улс гүрнүүд гадаад валютын нөөцөө юаниар бүрдүүлж, зарим улс (Зимбаби) үндэсний мөнгөн тэмдэгтээр юанийг хэрэглэх болов.

Хятадын удирдагч, эдийн засгийн шинэчлэлийн архитектор Дэн Сяопин 1982 оны 11 дүгээр сард хуралдсан ХКН-ын XII их хурлыг нээж хэлсэн үгэндээ: *«Марксизмын түгээмэл үнэнийг манай орны тодорхой бодит нөхцөл байдалтай холбож, өөрийн замаар явж, Хятадын онцлогтой социализм байгуулах нь урт хугацааны түүхэн туршлагыг задлан шинжилсэний үндсэн дээр бидний хийсэн гол дүгнэлт юм»* гэжээ. Энэхүү дүгнэлт хийх эргэлтийн цэг нь 1978 оны 12 дугаар сард хуралдсан ХКН-ын ТХ-ны 11 дэх удаагийн чуулганы III Бүгд хурал болсон юм.

Хятадын онцлогтой социализмын агуулга нь нийгэм-эдийн засгийн нэг байгууллын дотор ХКН-ын удирдлага дор социалист, капиталист өмчийн харилцаанд нэгэн зэрэг суурилсан “хөгжингүй” төгс социализмыг байгуулах явдал юм. Нөгөө талд «нэг улс, хоёр систем» хэмээх үзэл баримтлал нь Хятадын онцлогтой социализм байгуулах үндсэн зарчмуудын нэг бөгөөд Их Британий эзэмшлийн *Хонг Конг*, Португалийн эзэмшлийн *Макао* эх газрын Хятадад энхтайван замаар нэгтгэж, эдгээр засаг захиргааны тусгай бүсэд капиталист тогтолцоог наад зах нь 50 жил хадгалах явдал бөгөөд мөн ирээдүйд *Тайвань арлыг* энэ зарчмаар нэгтгэх явдал болно. Социализмын түгээмэл зүй тогтлоос ангид, өвөрмөгц онцлогтой болгож байгаа энэхүү үзэл баримтлалаар Хятад улсын дотор нийгмийн эсрэг тэсрэг хоёр өөр байгуулал болох социализм, капитализм зэрэгцэн орших боломжтой болсон юм. Энэхүү үзэл баримтлал нь «муур хар, цагаан байх нь тийм ч чухал биш, харин хулгана барьж идэж байгаа нь хамгийн чухал нь болой» гэсэн прагматик бодлогод

² В.Путин 2012 оны 3 дугаар сард ОХУ-ын Ерөнхийлөгчөөр гуравдахь удаагаа сонгогдсоны дараа гадаад анхны айлчлалаа мөн оны 6 дугаар сард БНХАУ-аас эхэлж, хоёр орны бүх талыг хамарсан стратегийн түншлэл (*Россия и Китай выйдут на новый уровень отношений-уровень всеобъемлющего стратегического партнерства*)-ийг шинэ түвшинд хүргэх тухай Бээжингийн Тунхаглалд гарын үсэг зурсан юм.

суурилжээ. Эдийн засгийн шинэчлэлийн бодлогын цөм нь «*нээлттэй хаалга*» байв. Үүнийг хэрэгжүүлэх эхний хувилбар нь хятадын асар том ажиллах хүч, зах зээлийг гадаадын хөрөнгө оруулалттай нэгт уялдуулсан экспортын чиглэлтэй «эдийн засгийн онцгой район», «худалдааны чөлөөт бүс»-ийг буй болгох явдал байв. Хүнсний хангамжийг шийдвэрлэх гол асуудал нь хүн амзүйн төлөвлөлт буюу демографийн бодлого байв. Хоцрогдсон орнууд нийгмийн хөгжлөө хурдасгаж хөгжингүй орнуудын эдийн засгийн түвшинд дөхөж ойртох бололцоо нь юуны өмнө хөрөнгөтнүүдийн үйлдвэрлэлийг удирдах аргад суралцах явдал гэж XIX зууны дундуур К.Маркс өөрийн бичсэн “*Энэтхэг дэх Их Британий эзэмшлийн ирээдүй үр дүн*” бүтээлдээ тов тодорхой томъёолсныг Дэн Сяопин иш үндэс болгож байв. Улс төрийн системд нам, төрийн удирдлага тав таван жилээр, нэг удаа улиран сонгогдохоор шинэчлэл хийсэн. Ши Жиньпин бол тав дахь үеийн удирдагч.

АНУ-ын нэрт олон улсын тоймч Тед Коппел тайлбарлахдаа: The People’s Republic of Capitalism буюу Ардын Бүгд Найрамдах Капитализм хэмээх өнөөгийн БНХАУ-д ХКН 1.4 тэрбум хүн амд бүрэн хүрч ажиллах боломжгүй, тиймийн учир үлдсэн хэсгийг капитализм авч явах учиртай. Үүнийг л Хятадын paradox гэж хэлээд байгаа юм гэжээ.

Хятадын онцлогтой социализмын туршлага бол байнга төвийг сахисан Швейцарь лугаа дахин давтагдашгүй юм. Нөгөө талаар энэ нь марксын сургаалийг орчин үеийн шинэ нөхцөлд баяжуулан хөгжүүлж буй хэрэг гэж хэлж болно. Хятадын онцлогтой социализм, «нэг улс, хоёр систем» үзэл баримтлал бол социалист байгуулалт, гадаад бодлого, олон улсын харилцааны онол, практик, улс төрийн шинжлэх ухааны хөгжилд оруулсан Дэн Сяопины цоо шинэ хийгээд жинтэй хувь нэмэр даруй мөн. Өөрөөр хэлбэл энэ нь социализмын асар их нөөц боломж, түүний давуу талыг нээн харуулж буй явдал юм. Коммунизмын үед хятадын онцлогтой социализмыг маш ихээр шүүмжлэн буруутгаж, марксизм-ленинизмыг хянан засварлаж байна, ХКН бол ревизионист нам гэж нэрлэж байсан. Улс төрийн шинэ сэтгэлгээ, өөрчлөн байгуулалтын үед М.Горбачев социализм олон хувилбартай, үндэсний онцлогтой байж болохыг хүлээн зөвшөөрсөн. Цөмийн зэвсэгтэй, НҮБ-ын АЗ-ийн хориг тавих эрхтэй байнгын гишүүн, 1.4 тэрбум хүн амтай БНХАУ-ын ДНБ 80 их наяд юань буюу 11.8 их ам. доллар, нэг хүнд ногдох орлого дундажаар 8.4 мянга, харин эдийн засгийн чөлөөт бүсүүдэд 25 мянган ам долларт хүрч, гадаад валютын нөөц 3 их наяд ам. доллар, алтны нөөц 12 мянга 400 тоннд хүрэв. Хүн амын 51 хувь буюу 784 сая иргэн дундаж орлогтой давхаргад шилжив. Энэ нь дундаж анги сүүлийн 10 жилд 2 дахин өссөн үзүүлэлт болж байна. Тэгвэл 2022 онд дундажаас дээгүүр орлоготой чинээлэг давхарга хүн амын 54 хувь болж, харин дундаж давхарга 22 хувь болж буурах ажээ. Нэг хүнд ногдох орлого дундажаар 16-гаас 34 мянган ам долларт хүрэх ажээ. Өнгөрсөн жилүүдэд жилд 13 сая ажлын байр шинээр нэмэгдэж, 60 сая хүн ядуурлаас гарсан нь Хятадын онцлогтой социализмын давуу талын үр дүн болж байна. Хятадын онцлогтой социализмын үсрэнгүй хөгжил олон улсын харилцааны олон туйлт шинэ дэг тогтолцоог бүрдүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлж байна гэж хэлж болно.

Аюулгүй байдал, геополитикт хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа мэдлэг, мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээнд суурилах нь аргазүйн нэн чухал ач холбогдолтой. Өнөөгийн даяаршсан ертөнцөд мэдлэг нэн чухал мэдээлэл болж, эргээд мэдээлэл нь нэн чухал мэдлэг болж байгаа явдал бөгөөд энэхүү эргэх орчилд судалгаа, дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээний ач холбогдол тасралтгүй өсөн нэмэгдсээр байна.

Аюулгүй байдлын онол, үзэл баримтлал, аргазүйд томоохон өөрчлөлт гарч, аюулгүй байдлыг хангах үндсэн үйл ажиллагаа бол аюулгүй байдалд нөлөөлж буй аюулын чиг хандлагын судалгаа, дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээ юм. Энэ нь аюулгүй байдалд

заналхийлж буй аюулын хэлбэрийн агуулга, шинж чанар өөрчлөгдөж, өргөжих, шинэ чиглэл рүү шилжиж буй зэрэг үйл явцыг ойлгож мэдэхийн тулд аюулгүй байдалд заналхийлж буй хэлбэрүүдийг олж тогтоох явдал ажгуу. Түүнчлэн аюулгүйжуулах (securitization) хэмээх шинэ ойлгол гарч ирэв.

Тийнхүү аюулгүй байдлын судлалд аюул судлал шинээр гарч ирж байна. 2001 оны 9 дүгээр сарын 11-ны Нью-Йорк, Вашингтонд болсон террорист ажиллагааны дараа байгуулагдсан НҮБ-ын Аюул, Сорилт, Өөрчлөлтийн асуудлаарх Дээд Түвшиний Зөвлөл (The High Level Panel on Threats, Challenges and Change of the United Nations) 2004 оны 12 дугаар сард «Илүү аюулгүй дэлхий ертөнц: Хамтын хариуцлагыг хуваалцахуй» илтгэлийг³ авч хэлэлцээд хүн төрөлхтний ирээдүйд заналхийлж буй дараах 10 аюулыг нэрлэсэн байна. Үүнд: 1. Ядуурал, 2. Халдварт өвчин, 3. Хүрээлэн буй орчны доройтол, 4. Улс хоорондын дайн, 5. Иргэний дайн, 6. Төрлөөр устгах, 7. Хүний наймаа, 8. Үйл олноор хөнөөх зэвсгийн тархалт, 9. Терроризм, 10. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг орно гэжээ. Үүн дээр засаглалын чанар маш чухал болж байна.

2012 оны 3 дугаар сараас Европын Холбооны (ЕХ) 7 дахь хөтөлбөрийн санхүүжүүлгээр «Трансатлантикийн харилцан ажиллагаа ба глобал засаглалыг төлөвшүүлэхэд түүний гүйцэтгэх үүрэг» сэдэвт төслийг хэрэгжүүлж буй бөгөөд ЕХ, АНУ, Түркийн think-tank 13 академик институтын “Transworld” консорциум түүнийг гүйцэтгэж байгаа юм. Төслийн хүрээнд “Олон улсын аюулгүй байдлын шинэ болон хувьслын чиг хандлага”⁴ сэдэвт хэлэлцүүлэг өрнүүлж байгаа юм. Аюулгүй байдал судлалын шинэ параметер нь: даяаршил, хүний аюулгүй байдал болон аюулгүйжуулалтад төвлөрч байгаа ажээ. Эмпирик судалгааны түвшинд: *нэгд*, шинэ аюулгүй байдлын сорилтын тоо, тухайлбал олон улсын терроризм, хүний эрүүл мэнд, амь насанд аюултай өвчний цар тахал, олон улсын цагаачлал, шилжилт хөдөлгөөн, дүрвэгсдийн асуудал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, эрчим хүчний аюулгүй байдал, цөмийн зэвсгийн тархалт, тэдгээрийн олон улсын аюулгүй байдлын системд үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ; *хоёрт*, БРИКС-ийн орнуудын сэргэн мандалт, олон улсын аюулгүй байдлын системд үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ, олон улсын харилцааны олон туйл глобал аюулгүй байдлын системийг тогтворгүй болгох магадлалтай өндөр болсоор байгаа; *гуравт*, дайны үндсэн шинж чанарт өөрчлөлт гарч, ялангуяа иргэний дайны өргөжилт, дотоодын тэмцэл, зөрчилдөөн тодорхой нутаг дэвсгэр, улс доторх мужууд гадны оролцоотойгоор бие даах, тусгаар тогтнох чиг хандлагатай болж байгаа явдал юм. Олон улсын терроризмтэй холбоотойгоор аюулгүйжуулах гол чиглэл нь санхүүгийн болон бусад бүртгэл, хяналт шалгалт, үйл олноор хөнөөх зэвсэглэлд тавих хяналт болж байна. Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх дэглэмийг өргөжүүлэхийн нэн чухлыг энд тэмдэглэх хэрэгтэй. Дээрх судлаачид иргэний дайны гол шалтгаан нь үндэсний гоморхол, зарга, шунал гэж үзжээ. Тиймээс НҮБ-ын энхийг сахиулах хүчний үйл ажиллагааны стратеги, менежмент, чадавхийг дээшлүүлэх, санхүүжүүлэлтийг өргөжүүлэх явдал чухал байгаа ажээ. Аюул судлалд уламжлалт бус аюул гэж нэрлэж буй тэдгээр нь хамрах орон зай, цаг хугацаа, үр дагвар нь ноцтой өөрчлөгдсөн гэсэн байна.

Эдүгээ мэдлэг болон технологит суурилсан эдийн засгийн онол-аргазүй, шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах, олон талт судалгаанд суурилсан дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай болж байна. Хүн төрөлхтөн шинжлэх ухаан-

³ Report of the High Level Panel on Threats, Challenges and Change «A More Secure World: Our Shared Responsibility». December 2004

⁴ Anne-Marie Le Gloanec, Bastien Irondele and David Cadier. «New and Evolving Trends in International Security»-“The Transatlantic Relationship and the Future Global Governance” Transworld, Working Paper 13, April 2013, ISSN 2281-5252

технологийн урьд үзэгдээгүй ахиц, дэвшлийг Шинэ мянганд гаргах материаллаг болон оюун санааны үлэмж чадавхтай юм. Мэдээлэл, харилцаа холбооны технологи, өндөр технологийн суурь бүтэц, дэд байгууламж, нэг хүнд оногдох нийтийг хамарсан өндөр хурдны интернетийн сүлжээ, гол эдийн засгийн бүтцүүдийн хоорондох интеграцлал, инновацчлал улс орны хөгжлийн гол хэмжүүр болов.

Зарчмын цоо шинэ үүрэгтэй болсон мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан орон зай, цаг хугацаа, эдийн засгийн шинжлэх ухааны хуучин тодорхойлолтууд шинчлэгдэж, энэ нь эдийн засагт асар их хэмнэлт буй болгож, цаг хугацааны алдагдалыг үлэмж бууруулах болов. Нэг талаас дэлхий дахины худалдаа-эдийн засаг, зах зээлийн харилцаанд мөнгө, санхүү, хөрөнгө, ажиллах хүчний асар өргөн шилжилт хөдөлгөөн, бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдлэг, мэдээлэлийн хил хязгааргүй урсгал явагдаж, улс орнуудын харилцан хамаарал урьд өмнө байгаагүйгээр гүнзгийрч, түүнд суурилсан даяаршсан макро шинэ ертөнц буй болж, нөгөө талд кибер хэмээх цоо шинэ орон зай, орчин буй болж, мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлөөс үүдэн мэдээллийн ертөнцөд томоохон өөрчлөлтүүд гарч, мэдээллийн аюулгүй байдал хэмээх шинэ ойлголт буй болов.

XX зууны сүүлчийн улиралд хүн төрөлхтний нэг том нээлт нь амьдрах геополитикийн орон зайгаа цоо шинээр “тэлсэн” явдал юм. Энэ шинэ орон зайг цахим орон зай буюу *cyber space* гэх бөгөөд хүний оюуны бүтээл болсон энэ орон зай хүн төрөлхтний амьдралд онцгой өөрчлөлт гаргаж, цаашид ч олон өөрчлөлт, шинэ зүйлсийг буй болгох нь тодорхой байна. Бодит биет бүхий ертөнц цахим ертөнцөд биет биш болж байгаа нь түүний хамгийн түгээмэл шинж юм.

Глобал орчинд бүх салбарт асар хурдацтай digital transition, digitalization явагдаж new business model, new markets болон job opportunities буй болж байна. Хүн төрөлхтөн аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын босгон дээр ирсэн байна.

Кибер технологийн хурдацтай хөгжлийн үг дагавараар дэлхий нийтийн аюулгүй байдал улам их эрсдэлтэй болж, санамсаргүй байдлаар өчүүхэн зүйлээс ч асар их хор хөнөөл учирч болзошгүй байдал үүсээд буй.

Үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болж, гадаад, дотоод бодлогын зааг ялгаа багсч байна. Цахим ертөнц ганцхан мэдээлэл солилцох хэрэгсэл байхаа хэдийнээ больж, хил хязгааргүй эдийн засгийн нэгдсэн нэг орон зай болсон байна. Өөр өөр соёл иргэншил, эдийн засаг, эрхзүйн тогтолцоотой 190 гаруй улс гүрэн интернетэд холбогдож, цахим сүлжээ нь бизнес, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, татвар, мэдээлэл, боловсрол, теле холбоо, ажил эрхлэлт, эрүүл мэнд энтертаймент гээд нийгмийн бүхий л харилцааг өөртөө нэгтгэж байна.

Глобал эдийн засагт гарч буй геополитик, гео-эдийн засгийн өөрчлөлтийг дүгнэвэл:

Нэгд, дэлхийн эдийн засаг даяаршиж, бие биенээсээ улам бүр харилцан хамааралтай болж, ямар ч хүчирхэг эдийн засаг, батлан хамгаалах хүч чадавхтай улс, гүрэн ч өөрийнхөө хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдлаа дангаараа хангаж, хөтлөн авч явах бололцоогүй болов, үүнийг 2011.09.11-ний Нью-Йорк, Вашингтонд болсон террорист үйл ажиллагаа, 2008-2009 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал харуулав.

Хоёрт, хөгжиж буй орнууд олон улсын банк, санхүүгийн байгууллагын заавар зөвлөмж, их гүрнүүдийн тусламж, нөлөө ивээл, үндэстэн дамнасан бизнес бүлэглэлүүдийн хөрөнгө оруулалт, хандив тусламжид улам бүр дулдуйдах болсон нь тэдгээр орнуудын хөгжлийн

асуудал, үндэсний аюулгүй байдлын тодорхой хэсэг дээрх байгууллага, улс, компанийн үйл ажиллагаанаас олон талаар хамаарах болж байгаа,

Гуравт, Зарчмын цоо шинэ үүрэгтэй болсон мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан орон зай, цаг хугацаа, хөршийн тухай уламжлалт ойлголт, эдийн засгийн шинжлэх ухааны хуучин тодорхойлолтууд шинчлэгдэж, энэ нь эдийн засагт асар их хэмнэлт буй болгож, цаг хугацааны алдагдалыг үлэмж бууруулах болов. Нэг талаас дэлхий дахины худалдаа-эдийн засаг, зах зээлийн харилцаанд мөнгө, санхүү, хөрөнгө, ажиллах хүчний асар өргөн шилжилт хөдөлгөөн, бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдлэг, мэдээллийн хил хязгааргүй урсгал явагдаж, улс орнуудын харилцан хамаарал урьд өмнө байгаагүйгээр гүнзгийрч, түүнд суурилсан даяарисан макро шинэ ертөнц буй болж, нөгөө талд кибер хэмээх цоо шинэ орон зай, орчин буй болж, мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлөөс үүдэн мэдээллийн ертөнцөд томоохон өөрчлөлтүүд гарч, мэдээллийн аюулгүй байдал хэмээх шинэ ойлголт буй болов. Нөгөө талаас мэдээлэл нь өөрөө үндэсний нөөц баялаг, улс орны хөгжил дэвшилд нөлөөлөх шийдвэрлэх хүчин зүйл болов. Кибер технологийн хурдацтай хөгжлийн уришгаар дэлхий нийтийн аюулгүй байдал улам их эрсдэлтэй болж, санамсаргүй байдлаар өчүүхэн зүйлээс ч асар их хор хөнөөл учирч болзошгүй байдал үүсээд буй.

Дөрөвт, Үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болов,

Тавд, Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалын төвд иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх явдлыг хангах, шинээр ажлын байрыг нэмэгдүүлэх явдал гарч ирэв. Ажил хөдөлмөр эрхэлж байнгын орлоготой байх нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах, сурч боловсрох, зээлийн болон бусад эрх нээгдэж, гэр бүл материаллаг аж байдлаа дээшлүүлэх өргөн боломж бүрдэх ажгуу. Шинжлэх ухаан, судалгаа, дүн шинжилгээнд суурилсан эдийн засгийн бодлого (Макро эдийн засгийн бодлого, төсвийн бодлого, мөнгөний бодлого, хөрөнгө оруулалтын бодлого, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого) явуулах нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл болов.

Зургаад, Дэлхийн нийтийн түгээмэл асуудал хурцадаж, хөгжлийн асуудал тэргүүн зэрэгт гарч ирсэн, олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдал улам бүр нарийн түвэгтэй болж буй, глобал харилцаанд хөгжиж буй орнуудын жин нөлөө эрс нэмэгдсэн зэрэг нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Байнгын гишүүдийг өргөтгөж, тивүүдийн тэгш төлөөлөлийг хангах шаардлагыг хойшлуулишгүйгээр тавьсаар байна.

Долоод, Олон улсын эрхзүйн үндсэн зарчмуудын нэг хүний эрхийг дээдлэх зарчим улс гүрний дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зарчмыг улам бүр үгүйсгэх болов.

Наймд, Аюулгүй байдлын уламжлалт үзэл баримтлал болсон улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал ба нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын хүчин зүйл хэвээр боловч, харин хүний аюулгүй байдал дээр улам бүр төвлөрөх болов.

Есд, Ардчилалыг социал медиад тулгуурлан түгээн дэлгэрүүлэх, “өнгөт” хувьсгал хийх гэсэн оролдлого эцсийн дүндээ ноцтой үр дагаварт хүрсний Арабын хавар, Украины хямрал харуулав.

Аравт, Европын Холбооны интеграци томоохон сорилттой тулгарч байгаа нь олон улсын харилцаа, глобал эдийн засгийн харилцаанд интеграцлалын үйл явц цорын ганц боломж

биш гэдэг нь тодорхой болсоор буй, дүрвэгсэдийн давалгаа, BREXIT, шинэ нөхцөл байдлыг буй болгов. ЕХ-ны ирээдүйн хувь заяа ихээхэн бүрхэг болов.

Арваннэгт, Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт улам бүр хөнгөвчлөгдөж, ДХБ-аар зохицуулагдах болж, чөлөөт худалдааны бүс нутаг, гэрээ хэлэлцээр байгуулах үйл явц өргөжиж байгаа боловч энэ нь улс орнуудын үндэсний аюулгүй байдалд ноцтой нөлөөлж, нөгөө талд эдийн засгийн протекционизм нэг орны хүрээнээс хальж бүс нутгийн хүрээнд ишлжих хандлага ч ажиглагдах болсон,

Арванхоёрт, Британий Лорд, Ерөнхий сайд агсан Вискоунт Палмерстоны (1784-1865) хэлсэн «Англи улсад мөнхий анд нөхөр гэж байхгүй, мөнхий дайсан ч гэж байхгүй, гагцхүү мөнхийн эрх ашиг л гэж буй» хэмээх үг дахин сонсогдож эхлэв. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Д.Трампа ялснаар АНУ нэгдүгээрт гэж мэдэгдэн, Транс-Номхон далайн түншлэлээс татгалзаж, НАФТА-г шинэчлэх, НҮБ, НАТО, ЕХ-ны талаарх уламжлалт байр суурь нь мэдэгдэхүйц өөрчлөгдөх төлөвтэй болов. Дангаариших, эдийн засгийн илүү протекционист бодлого баримталж эхлэв. ЕХ-ны Үндсэн хууль гишүүн орнуудын үндэсний хууль тогтоомжоос дээгүүр тавигдана гэсэн заалт ЕХ-ны Лиссабоны гэрээнд тусгагдсан нь гишүүн улсуудын бие даасан байдалд сөргөөр нөлөөлж эхлэв. Үндэсний эрх ашиг, глобал эрх ашгийн тэнцвэр нэн чухал болов. Даяаршил, мэдээллийн технологийн эрин үед хэн нь анд нөхөр, хэн нь дайсан гэдэг нь үндсэндээ бүрхэг болсон.

Арвангуравт, Дэлхий дахины болон бүс нутгийн нарийн түвэгтэй асуудлуудыг шийдвэрлэхэд НҮБ гэхээс илүүтэй Их 20-ийн бүлэг, Их наймын бүлэг (эдүгээ G7 болсон), ЕХ, НАТО тодорхой үүрэг гүйцэтгэх болов.

Арвандөрөвт, Бүс нутгийн интеграциуд өөр хоорондоо хамтын ажиллагаагаар холбогдож транс-континенталь шинж чанартай болж байгаа нь хамтын ажиллагааны шинэ хэлбэрийг буй болгов, үүний мод илрэл нь АСЕМ (Asia-Europe Meeting), FEALAC (Forum for East Asia-Latin America Cooperation), AFEM (Africa-Europe Meeting) болж байна.

Арвантавд, Хүний эрх, үндсэн эрх чөлөө, ардчилалын асуудал нь дан гагц тухайн улсын дотоод хэрэг биш, харин олон улсын түгээмэл шинж чанартай бөгөөд олон улсын шийтгэлтэй болов, Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын Дүрэм (Rome Statute of the International Criminal Court) 1998 оны 7 дугаар сарын 17-нд батлагдаж, 2002 оны 7 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсноор Нидерландын Хаага хотноо байгуулагдсан байнгын ажиллагаатай шүүх үйл ажиллагаагаар эхэлж, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, төрлөөр устгах (genocide), дайны гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэргийг шүүх олон улсын эрхзүйн үндэс тавигдав. 2014 оны 4 дугаар сарын 1-ний байдлаар Ромын Дүрэмд 122 улс нэгдсэн байна.

Арванзургаад, Олон улсын харилцааны олон туйлт шинэ дэг тогтолцоо төлөвших хандлага идэвхиж байгаа нь хүйтэн дайн дууссанаас хойш тогтсоор ирсэн олон улсын аюулгүй байдлын системд ноцтой сөрөг нөлөө үзүүлж байна. ОХУ Украины нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд заналхийлж, Крымын хойгийг хүчин түрэн өөртэй албадан нэгтгэж (annexation), БНХАУ Японтой маргаантай газар нутгийн бүсэд дангаар өөрийн агаарын халдашгүй орон зайн бүс тогтоосон, хэдийгээр Курилын арлууд нь ОХУ-ын нутаг дэвсгэр ч 2014 оны 8 дугаар сард тэнд өдөөн хатгасан шинжтэй цэргийн томоохон хээрийн сургуулилт хийж, стратегийн бөмбөгдөгч онгоцууд нь ЕХ-ны гишүүн орнуудын хилийг байнга зөрчих болж, цэргийн хөлөг онгоцууд нь ЕХ-ны зарим улсын болон Австралийн ойролцоо эргүүл хийх болсон зэргээс тодорхой харагдаж байна. Энэ нь цаашид даамжирвал глобал аюулгүй байдалд томоохон заналхийлэл буй болохоор байна. Сирийн

иргэний сунжрал, Өмнөд Хятадын тэнгисийн арлын маргааны даамжрал дээрхтэй шууд холбогдоно.

Арвандолоод, Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, байгаль-экологийн гамшиг, олон улсын терроризм, уламжлалт бус шинэ өвчний цар тахал, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг (хар тамхи, мансууруулах бодисын хууль бус наймаа, бохир мөнгө угаах ажиллагаа, зэвсгийн хууль бус худалдаа, хүний наймаа болон бусад), салан тусгаарлах ажиллагаа, шашины харгис урсгалын нөлөө, хууль бус цагаачлал, ажиллах хүчний олон улсын шилжилт хөдөлгөөн, дүрвэгсдийн давалгаа зэрэг уламжлалт бус (hybrid) аюул үндэсний болон глобал улс төр-эдийн засагт ноцтой уршиг тарих болсон,

Арваннаймд, Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт ургамал, амьтны аймгийн олон төрөл зүйл устах, гол мөрөн, тэнгис нуур ширгэж үгүй болоход хүргэж, байгалийн гамшигийн давтамжийн мөчлөг улам бүр ойртох болов. Энэ нь хүмүүсийн амьдрал, аж байдлын хэв маягт шууд нөлөөлж, гол нь хүн төрөлхтөн үүнд дасан зохицох шаардлагатай болов.

Арванесд, Шавхагдашгүй биш болох нь тодорхой болсон манай гаригийн нөөц баялаг, хүн амын өсөлт, хүнс тэжээлийн хомсдол, өлсгөлөн, ядуурал нь глобаль шинжтэй болж, эрчим хүчний төлөөх тэмцэл тэргүүн ээлжинд гарч ирэв.

Хорьд, Дэлхий нийтэд ардчилал хөгжиж буй гэх боловч сайн засаглалын төлөвшил, ардчилал, хүний эрхийн баталгаажилт ихээхэн эмзэг, сул байгаа нь хүний аюулгүй байдлын тогтолцоонд улам бүр сөрөг нөлөө үзүүлсээр буй,

Хориннэгд, Хүйтэн дайнаас үлдсэн цорын ганц бүс нутаг Солонгосын хойгийн хурцадмал байдал даамжирч, Хойд Солонгосын цөмийн болон баллистик пуужингийн хөтөлбөр бүс нутгийн улсуудын (Монгол Улсад) аюулгүй байдалд шууд заналхийлсээр буй,

Хоринхоёрт, ОХУ, БНХАУ тэргүүлсэн олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг журам (polycentric world order) төлөвшиж буй нь нэгэнт бодит зүйл болов.

Хорингуравт, Төв рүү тэмүүлэх, төвөөс зугтаах хүчний аль аль нь үйлчилж буй даяаршлын эрин үед олон улсын харилцааны шинэ дэг журам төлөвших үйл явцын төгсгөлийг төсөөлөх боломж тун бүрхэг байгаа зэрэг санал, дүгнэлтүүд юм.

Тиймээс дэлхийн хамтын нийгэмлэг, улс орнууд, тэдгээрийн харилцаа, хамтын ажиллагааны өмнө томоохон зорилт, сорилт тулгарч байгаа нь тодорхой байна.